



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ 8
ДУГААР САРЫН ТАНИЛЦУУЛГА


ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН 2020 ОНЫ 8 ДУГААР САРЫН ТАНИЛЦУУЛГА

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
2020.09.15


БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



Хөдөлмөр, Халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй иргэд жил бүрийн 8 сарын байдлаар



Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2020 оны эхний 8 сарын байдлаар




Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 8 дугаар сарын эцэст 932 байгаа нь өмнөх оны мөн үеэс 15 (1.6%) хүнээр, өмнөх сараас 63 (7.2%) хүнээр өсөж, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 456 (48.9%) эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 23 (2.5%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба 14 (60.9%) эмэгтэйчүүд байна.



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИК
ТӨВӨН


Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2020 оны 8 сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.6 хувийг бүрэн дунд, 27.5 хувийг дипломын болон бакалаврын дээд, 7.7 хувийг техник мэргэжлийн, 5.0 хувийг суурь, 3.3 хувийг тусгай мэргэжлийн дунд, 1.3 хувийг бага, 1.6 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.3 хувийг 15-34 насны залуучууд, 39.8 хувийг 35-54 насныхан, 6.9 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.

ЭРҮҮЛ МЭНД



Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 8 сарын байдлаар 968 эх амаржиж, 976 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 48 (5.2%)-аар, амьд төрсөн хүүхэд 46 (4.9%)-аар тус тус өссөн байна. Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 2020 оны эхний 8 сард 9 болж, өмнөх оны мөн үеэс 9 (50.0%)-аар, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 болж, өмнөх оны мөн үеэс 3 (75.0%)-аар тус тус буурсан байна.



МӨНГӨ, ЗЭЭЛ

Зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 08 сард 122.6 тэрбум төгрөг байгаа ба 0.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна. Харицахын үлдэгдэл 2020 оны 08 сард 18.2 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 14.7 тэрбум буюу 80.5 хувийг эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл 2020 оны 08 сард 109.6 тэрбум төгрөгт хүрчээ.



МОНГОЛЫН УЛСЫН СТАТИСТИК

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2020 оны 08 сард өмнөх оны мөн үеэс 3.4 хувь, жилийн эцсээс 3.3 хувиар өсч, өмнөх сараас 0.4 хувиар буурсан байна.

Ерөнхий индекс 2020 оны 08 сард өмнөх сараас 0.4 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, ус бүлгийн индекс 2.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн ба тус бүлгийн индекст өндөр хувийн жин эзэлдэг мах, хүнсний ногооны үнэ өмнөх сараас буурсан нь бүлгийн индекс буурах шалтгаан болсон.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр, 2015=100%


Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020-08 2019-08	2020-08 2019-12	2020-08 2020-07
Ерөнхий индекс	100.0	103.4	103.3	99.6
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	111.1	114.8	97.5
Согтууруулах ундаа, тамхи	3.2	102.1	101.4	100.0
Хувцас, бөс бараа, гутал	16.1	104.3	101.7	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	102.6	100.3	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	103.0	102.5	100.9
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.9	104.2	100.0
Тээвэр	12.2	94.8	96.0	100.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.4	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	99.5	100.5	100.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.4	100.4	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	100.6	100.4	100.0

АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2020 оны 8 дугаар сарын байдлаар 7 тэрбум 565.5 сая төгрөгт хүрчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 80.9 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл, 8.2 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 10.9 хувийг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар тус тус эзэлж байна. Нийт 7 тэрбум 890.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, 8 сар, сая төгрөг



■ Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл
■ Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт

ХӨДӨӨ АЖ АХУЙ




Аймгийн хэмжээнд 2020 оны 8 дугаар сарын байдлаар төллөх насны 1524.9 мянган хээлтэгч малын 1241.9 мянга буюу 81.4 хувь нь төллөсөн байна. Эм ямааны 80.6 хувь, эм хонины 85.9 хувь, гүүний 72.3 хувь, үнээний 72.6 хувь, ингэний 72.3 хувь нь төллөжээ. Нийт гарсан төл 1231.4 мянган болж 99.0 хувьтай бойжиж байна.

Том малын зүй бусын хорогдол 2020 оны 8 дугаар сард аймгийн хэмжээнд 10118 толгой болж, өмнөх оны мөн үетэй харьцуулвал 27114 толгой буюу 3.7 дахин буурсан байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 595, үхэр 476, тэмээ 38, хонь 2891, ямаа 6118 байна. Нийт хорогдлын 28.5 хувийг хонь, 60.5 хувийг ямаа эзэлж байна.



МОНГОЛЫН
УЛСЫН
СТАТИСТИК
ТӨВРӨГ

Хорогдсон том мал, 2020 оны 8-р сарын байдлаар



2018



WWW.1212.MN

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН
МЭДЭЭЛЛЭЭ аваарай



Data lab

тооллого судалгааны микро мэдээллийн сан



SOCIAL NETWORK



[www.facebook.com/
StatisticMongolia/](http://www.facebook.com/StatisticMongolia/)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)

ЛАВЛАХ УТАС



1900-1212

ЦАХИМ ШУУДАН



information@nso.mn



ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠯᠤᠯᠤᠰ
ᠲᠤᠨ
ᠰᠤᠳᠤᠰᠤᠨ
ᠰᠤᠲᠤᠰᠢᠬᠢ
ᠲᠤᠨ
ᠮᠤᠨᠤ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Говь-Алтай аймаг,
Засаг даргын дэгэдэх Статистикийн хэлтэс
Утас : (7048-4278)
(7048-3442)

Вэб: govi-altai.nso.mn

www.1212.mn

И_мэйл хаяг: stat_altai@yahoo.com

govi-altai@nso.mn